

Аж ахуйн нэгж, байгууллагын 201... оны үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээ

I. Хаягийн хэсэг

1. Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг

Регистрийн дугаар							
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр							
Байршил	Нэр			Код			
Аймаг, нийслэл							
Сум, дүүрэг							
Баг, хороо							
Гудамж, хороолол							
Байшин, байр							
Хашаа, хаалганы дугаар							
Утас							
Факс							
Цахим шуудан							
Цахим хуудас				http://			

1. Аж ахуйн нэгж, байгууллагууд дараа оны 3-р сарын 1-ний дотор аймаг, нийслэл (дүүрэг)-ийн статистикийн газар, хэлтэст цахим болон маягтаар ирүүлнэ.

2. Аймаг, нийслэл (дүүрэг)-ийн статистикийн газар, хэлтэс 3-р сарын 12-нд Үндэсний статистикийн хороонд цахим шуудангаар дамжуулна.

3. Шууд мэдээлдэг яам, бусад газар 3-р сарын 12-ны дотор Үндэсний статистикийн хороонд цахим шуудангаар дамжуулна.

2. Холбоо барих хүний талаарх мэдээлэл

Овог, нэр	
Албан тушаал	
Утас	
Гар утас	
Факс	
Цахим шуудан	

3. Хариуцлагын хэлбэр

Нэр	Код
Хувьцаат компани	10
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	11
Бүх гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	20
Зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	21
Хоршоо	30
Төрийн өмчит үйлдвэрийн газар	40
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	41
Төсөвт байгууллага	60
Төрийн бус байгууллага	70
Сан	71
Бусад	80

4. Өмчийн хэлбэр

	Нэр	Хувь	Код
Төрийн	өмчийн		11
	өмчийн оролцоотой %	12
	хамтарсан %	13
Орон нутгийн	өмчийн		31
	өмчийн оролцоотой %	32
	хамтарсан %	33
Хувийн	Монгол Улсын		21
	гадаадтай хамтарсан %	22
	гадаад улсын		23

5. Үйл ажиллагааны чиглэл

ЭЗҮАСА-4.0 код*

1. _____	<input type="text"/>
2. _____	<input type="text"/>
3. _____	<input type="text"/>
4. _____	<input type="text"/>
5. _____	<input type="text"/>
6. _____	<input type="text"/>

* - Кодыг статистикийн хэлтсийн мэргэжилтэн нөхнө.

II. Нийт орлого

Үзүүлэлт	МД	Дансны үндсэн ангилал	Үнийн дүн (мян.төг)
А	Б	В	1
Нийт орлого <i>мөр201=мөр(202+207+211+212)</i>	201	Х	
Борлуулалтын орлого <i>мөр202=мөр(203 ÷ 206)</i> <i>(бүлэг III, мөр 301, багана1-ийн харгалзах дүнтэй тэнцүү)</i>	202	51-р дансны холбогдох дүн	
- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн борлуулалтын орлого	203		
- Үйлчилгээний орлого	204		
- Худалдаж авсан барааг борлуулсны орлого	205		
- Лизингийн үйл ажиллагаа эрхэлдэг нэгжийн хүүгийн орлого	206		
Өөрийн эцсийн хэрэглээнд зарцуулсан бараа бүтээгдэхүүн <i>мөр207=мөр(208 ÷ 210)</i>	207		
- Харьяа газарт шилжүүлсэн өөрийн бүтээгдэхүүн	208		
- Өөртөө хэрэглэсэн бүтээгдэхүүн	209		
- Ажиллагчиддаа цалин хэлбэрээр олгосон бүтээгдэхүүн	210		
Улсын төсвөөс авсан татаас	211		84-р дансны холбогдох дүн
Үндсэн бус үйл ажиллагааны орлого <i>мөр212=мөр(213 ÷ 223)</i>	212		
- Үндсэн хөрөнгө худалдсаны орлого	213		
- Барилга, байшин түрээслүүлсний орлого	214		
- Машин, тоног төхөөрөмж түрээслүүлсний орлого	215		
- Хүүгийн орлого	216		
- Үнэт цаасны арилжааны орлого	217		
- Торгуулийн орлого	218		
- Ногдол ашгийн орлого	219		
- Даатгалын байгууллагаас авсан нөхөн төлбөр	220		
- Хандив, тусламжийн орлого	221		
- Гадаад валютын ханшийн зөрүүний олз	222		
- Бусад орлого	223		

III. Борлуулалтын орлого, эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар

Үйл ажиллагааны чиглэл	ЭЗҮАСА-4.0 код*	МД	Үнийн дүн (мян.төг)
А	Б	В	1
Борлуулалтын орлого, бүгд <i>мөр301=мөр(302 ÷ 318)</i> <i>(бүлэг II, мөр 202, багана1-ийн харгалзах дүнтэй тэнцүү)</i>		301	
	_ _ _ _ _ _ _	302	
	_ _ _ _ _ _ _	303	
	_ _ _ _ _ _ _	304	
	_ _ _ _ _ _ _	305	
	_ _ _ _ _ _ _	306	
	_ _ _ _ _ _ _	307	
	_ _ _ _ _ _ _	308	
	_ _ _ _ _ _ _	309	
	_ _ _ _ _ _ _	310	
	_ _ _ _ _ _ _	311	
	_ _ _ _ _ _ _	312	
	_ _ _ _ _ _ _	313	
	_ _ _ _ _ _ _	314	
	_ _ _ _ _ _ _	315	
	_ _ _ _ _ _ _	316	
	_ _ _ _ _ _ _	317	
	_ _ _ _ _ _ _	318	

* - Кодыг статистикийн хэлтсийн мэргэжилтэн нөхнө.

IV. Нийт зардал

Үзүүлэлт	МД	Дансны үндсэн ангилал	Үнийн дүн (мян.төг)	
			Оны эхэнд	Оны эцэст
А	Б	В	1	2
Түүхий эд, материалын зардал (бүлэг VII, мөр 701, багана 5-ын харгалзах дүнтэй тэнцүү)	401	14-р дансны холбогдох кредит дүн		
Дахин борлуулахаар худалдан авсан барааны өртөг	402	61-р дансны холбогдох кредит дүн		
Үйлчилгээний зардал (бүлэг VI, мөр 601 багана 1-ийн харгалзах дүнтэй тэнцүү)	403			
Нийт цалин хөлс <i>мөр404=мөр(405÷407)</i>	404			
- Цалин хөлс (бүлэг VIII, мөр 805, багана 1-ийн харгалзах дүнтэй тэнцүү)	405	31-р дансны холбогдох кредит дүн		
- Ажиллагчдад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн шагнал, урамшуулал, тусламж, дэмжлэг (бүлэг VIII, мөр 806, багана 1-ийн харгалзах дүнтэй тэнцүү)	406			
- Аж ахуйн нэгжээс төлсөн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл (бүлэг VIII, мөр 807, багана 1-ийн харгалзах дүнтэй тэнцүү)	407			
Бусад зардал <i>мөр408=мөр(409÷414)</i>	408	х		
- Үндсэн хөрөнгийн элэгдэл	409	20-р дансны холбогдох дүн		
- Найдваргүй авлагын зардал	410	87-р дансны холбогдох дүн		
- Хандивын зардал	411			
- Ногдол ашгийн зардал	412			
- Торгуулийн зардал	413			
- Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	414			
Татвар, хураамж	415			
Нийт зардал <i>мөр416=мөр(401÷404+408+415)</i>	416	х		
Ашиг/алдагдал <i>мөр417=мөр(201-416)</i>	417	х		

V. Материаллаг эргэлтийн хөрөнгийн нөөц

Үзүүлэлт	МД	Дансны үндсэн ангилал	Үнийн дүн (мян.төг)	
			Оны эхэнд	Оны эцэст
А	Б	В	1	2
Түүхий эд, материал (бүлэг VII, мөр701, багана 1, 2-ын харгалзах дүнтэй тэнцүү)	501	14-р дансны холбогдох дүн		
Хагас боловсруулсан бүтээгдэхүүн (дуусаагүй үйлдвэрлэл)	502			
Бэлэн бүтээгдэхүүн	503	15-р дансны холбогдох дүн		
Мал, амьтад	504			
Дахин борлуулахаар худалдан авсан бараа (бүлэг VII, мөр 701, багана 3, 4-ийн харгалзах дүнтэй тэнцүү)	505			
Сав баглаа, боодол	506			
Нийт нөөц <i>мөр507=мөр(501÷506)</i>	507	х		

VI. Үйлчилгээний зардал, нэр төрлөөр

Нэр төрөл	МД	Нийт дүн (мян.төг)
А	Б	1
Үйлчилгээний зардал, бүгд	601	
<i>мөр601=мөр(602 ÷ 630)</i>		
Барилгын ажил, үйлчилгээ, урсгал засвар	602	
Зочид буудал, хоол ундаар хангах үйлчилгээ	603	
Томилолт (унаа)	604	
Томилолт (байр, хоол)	605	
Тээврийн зардал (зорчигч)	606	
Тээврийн зардал (ачаа)	607	
Шуудан	608	
Холбоо, интернетийн төлбөр	609	
Банк, санхүүгийн үйлчилгээний зардал	610	
Зээл, бусад авлагыг барагдуулах зардал	611	
Зээлийн хүү	612	
Даатгалын төлбөр	613	
Барилга, байшингийн түрээс	614	
Машин, тоног төхөөрөмжийн түрээс	615	
Судалгаа, шинжилгээний ажил	616	
Хууль, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ	617	
Бизнесийн зөвлөгөө өгөх, програм хангамж зохиох, зураг төсөл боловсруулах үйлчилгээ	618	
Мал эмнэлгийн үйлчилгээ	619	
Зар сурталчилгаа	620	
Аялал, хурал цуглаан зохион байгуулах	621	
Хөдөө аж ахуй, уул уурхай, эрчим хүч, усны туслах үйл ажиллагааны зардал	622	
Машин, тоног төхөөрөмж, барааны засварлалт, угсралтын үйлчилгээ	623	
Боловсруулах үйлдвэрийн туслах үйлчилгээ	624	
Ажиллагчдын сургалтын зардал	625	
Эрүүл мэндийн үйлчилгээ	626	
Бохир ус, хог хаягдал, байгаль орчныг хамгаалах үйлчилгээ	627	
Гишүүнчлэл бүхий байгууллагаар үйлчлүүлсний зардал	628	
Чөлөөт цаг, биеийн тамир, соёлын үйлчилгээ	629	
Цэвэрлэгээ, гоо сайхан, бусад үйлчилгээ	630	

Тод хараар тэмдэглэсэн үзүүлэлт нь IV бүлгийн харгалзах дүнтэй тэнцүү байна.

VII. Түүхий эд, материалын зардал, бүтээгдэхүүний нэр төрлөөр

мян.төг

Нэр төрөл	МД	Түүхий эд, бараа материал		Дахин борлуулахаар худалдан авсан бараа		Зарцуулсан зардал
		Оны эхэнд	Оны эцэст	Оны эхэнд	Оны эцэст	
А	Б	1	2	3	4	5
Түүхий эд, материалын зардал, бүгд <i>мөр701=мөр(702 ÷ 741)</i>	701					
Үр тариа, жимс, хүнсний ногоо, бусад газар тариалангийн бүтээгдэхүүн	702					
Арьс, шир, ноос, ноолуур, өндөг, зөгийн бал, бусад мал, амьтаны гаралтай бүтээгдэхүүн	703					
Модны суулгац, мод бэлтгэлийн бүтээгдэхүүн	704					
Загас, загасан бүтээгдэхүүн	705					
Нүүрс	706					
Цахилгаан эрчим хүч	707					
Дулааны эрчим хүч	708					
Үйлдвэр, ундны ус	709					
Хий	710					
Түлшний мод, аргал, хөрзөн	711					
Шахмал түлш болон кокс	712					
Шатахуун, шатах, тослох материал	713					
Боловсруулаагүй газрын тос	714					
Төмөр, зэс, молибдени, цайр, хөнгөн цагаан	715					
Чулуу, элс, хайрга, шавар	716					
Хайлуур жонш, шохой, үнэт чулуу, давс, бусад эрдэс бүтээгдэхүүн	717					
Мах, махан бүтээгдэхүүн	718					
Сүү, сүүн бүтээгдэхүүн	719					
Хүнсний бусад бүтээгдэхүүн	720					
Малын тэжээл	721					
Согтууруулах, согтууруулах бус ундаа	722					
Тамхины түүхий эд	723					
Ээрсэн утас, нэхмэл даавуу	724					
Хувцас, сүлжмэл, үслэг эдлэл	725					
Хөдөлмөр аюулгүй байдлын зориулалттай хувцас, хэрэгсэл	726					
Гутал, савхи, савхин бүтээгдэхүүн	727					
Зүсмэл материал, банз, бусад модон бүтээгдэхүүн	728					
Цаас, цаасан бүтээгдэхүүн	729					
Ном, сонин болон бусад хэвлэмэл бүтээгдэхүүн	730					

Тод хараар тэмдэглэсэн үзүүлэлт нь IV, V бүлгийн харгалзах дүнтэй тэнцүү байна.

VII. Түүхий эд, материалын зардал, бүтээгдэхүүний нэр төрлөөр

(үргэлжлэл)

мян.төг

Зардлын нэр төрөл	МД	Түүхий эд, бараа материал		Дахин борлуулахаар худалдан авсан бараа		Зарцуулсан зардал
		Оны эхэнд	Оны эцэст	Оны эхэнд	Оны эцэст	
А	Б	1	2	3	4	5
Эм тариа, эм зүйн бүтээгдэхүүн	731					
Саван, цэвэрлэгээний бүтээгдэхүүн	732					
Химийн бусад бүтээгдэхүүн	733					
Резинэн, хуванцар бүтээгдэхүүн	734					
Шил, шилэн бүтээгдэхүүн	735					
Бетон, цемент, шохой, тоосго, блок, хавтан зэрэг бүтээгдэхүүн	736					
Цахилгаан утас, багаж хэрэгсэл, холбооны тоног төхөөрөмж	737					
Металл бэлдэц, цувимал, ган бөмбөлөг	738					
Төмөр хаалга, цонх, гэр ахуйн төмөр эдлэл	739					
Үйлдвэрлэлийн бусад бүтээгдэхүүн	740					
Сэлбэг, эд ангийн зардал <i>мөр741=мөр(742 ÷ 745)</i>	741					
- Үйлдвэрийн болон хөдөө аж ахуйн зориулалттай машин, тоног төхөөрөмжийн сэлбэг, эд анги	742					
- Албан тасалгааны зориулалттай тоног төхөөрөмжийн сэлбэг, эд анги	743					
- Тээврийн хэрэгслийн сэлбэг, эд анги	744					
- Эмчилгээний хэрэгсэл, нарийн хэмжил, хараа зүйн багаж хэрэгслийн сэлбэг, эд анги	745					

VIII. Ажиллагчдын тоо, цалин хөлс

Үзүүлэлт	МД	Бүгд	Бүтэн цагаар		Үүнээс: эмэгтэй
			Бүтэн цагаар	Бүрэн бус цагаар	
А	Б	1=2+3	2	3	4
Ажиллагчдын тоо	801				
Үүнээс: судалгаа, шинжилгээний ажиллагчид	802				
Ажилласан цаг	803				
Нийт цалин хөлс <i>мөр804=мөр(805 ÷ 807)</i>	804				
- Цалин хөлс (мян.төг)	805				
- Ажиллагчдад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн шагнал, урамшуулал, тусламж, дэмжлэг (мян.төг)	806				
- Ажиллагчдад олгосон нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл (мян.төг)	807				

Тод хараар тэмдэглэсэн үзүүлэлт нь IV бүлгийн харгалзах дүнтэй тэнцүү байна.

IX. Хөрөнгийн нийт хуримтлал

мян.төг

Үзүүлэлт	ДҮА	МД	Оны эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Эх үүсвэрээр										Хасагдсан	Оны эцсийн үлдэгдэл
					Дотоодын	Төсвийн хөрөнгө оруулалт	Банкны зээл	Өөрийн хөрөнгө оруулалт	Бусад эх үүсвэр	Гадаадын	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	Зээл	Гадаадын буцалтгүй тусламж	Бусад эх үүсвэр		
А	Б	В	1	2=3+8	3=4+7	4	5	6	7	8=9+12	9	10	11	12	13	14=1+2-13
Үндсэн хөрөнгө <i>мөр901 = мөр(902+903+907+912+915+916)</i>		901														
Орон сууцны барилга		902														
Бусад барилга, байгууламж <i>мөр903=мөр(904 ÷ 906)</i>		903														
- Орон сууцны бус барилга		904														
- Бусад байгууламж		905														
- Газар, хөрс сайжруулалт		906														
Машин, тоног төхөөрөмж <i>мөр907=мөр(908 ÷ 910)</i>		907														
- Тээврийн хэрэгсэл		908														
- Мэдээлэл, холбооны тоног төхөөрөмж		909														
- Бусад машин, тоног төхөөрөмж <i>мөр910>=мөр911</i>		910														
Үүнээс: Тавилга, эд хогшил		911														
Өсөж үрждэг хөрөнгө <i>мөр912=мөр(913+914)</i>		912														
- Мал, амьтад		913														
- Олон наст ургамал		914														
Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийг эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардал		915														
Оюуны өмчийн бүтээгдэхүүн <i>мөр916 = мөр(917 ÷ 919+922+923)</i>		916														
- Судалгаа, шинжилгээний ажил		917														
- Геологи хайгуулын ажил		918														
- Компьютерийн программ хангамж, мэдээллийн сан <i>мөр919= мөр(920+921)</i>		919														
- Компьютерийн програм хангамж		920														
- Мэдээллийн сан		921														
- Утга зохиол, урлагийн эх бүтээл		922														
- Оюуны өмчийн бусад хөрөнгө		923														
Үнэт зүйлс <i>мөр924=мөр(925 ÷ 927)</i>		924														
- Үнэт металл, чулуу		925														
- Эртний эдлэл, гар урлалын бүтээл		926														
- Бусад үнэт зүйлс		927														

20-р дансны холбогдох дүнгээр нөхнө

Тамга тэмдэг

Захирал (Эзэн).....

Ерөнхий (ахлах)нягтлан бодогч.....

Эдийн засагч.....

201... оны ... сарын ... өдөр

Маягт нөхөх заавар

Энэхүү тайланг өмчийн бүх хэлбэрийн санхүүгийн тайлан тэнцэл гаргадаг аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон хугацаанд нь үнэн зөв, бүрэн нөхөж ирүүлнэ.

I. Хаягийн хэсэг

Аж ахуйн нэгж, байгууллагын хаяг. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсанаар товчлохгүйгээр нөхнө.

Аж ахуйн нэгж, байгууллагын оршин байгаа аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хороо, гудамж хороолол, байшин, байр, хашаа хаалганы дугаар, тухайн байгууллагын утасны дугаар, цахим хаяг зэрэг үзүүлэлтүүдийг нөхнө.

Холбоо барих хүний талаарх мэдээлэл. Энэ хэсэгт тухайн аж ахуйн нэгж, байгууллагын дарга эсвэл нягтлан бодогчийн овог нэр, албан тушаал, суурин болон гар утасны дугаар, факс, цахим хаяг зэрэг үзүүлэлтүүдийг нөхнө.

Хариуцлага болон өмчийн хэлбэр. Тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн байгууллагын хариуцлагын болон өмчийн хэлбэрийг нөхөхдөө холбогдох кодыг дугуйлна.

Өмчийн хэлбэр нь хамтарсан аж ахуйн нэгжийн хувьд өмчийн эзлэх хувийг нөхөх бөгөөд хэрэв төрийн хамтарсан бол төрийн өмчийн эзлэх хувийг, орон нутгийн хамтарсан бол орон нутгийн өмчийн эзлэх хувийг, хувийн хамтарсан бол гадаадын өмчийн эзлэх хувийг тус тус нөхнө.

Үйл ажиллагааны чиглэл. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн үйл ажиллагааны стандарт ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ. Жишээ нь: компьютерийн сэлбэг хэрэгслийн жижиглэнгийн худалдаа, талх нарийн боовны жижиглэнгийн худалдаа гэж сайтар ялган бичиж өгнө.

Үйл ажиллагааны чиглэлийн кодыг 5 оронгийн түвшинд "Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал" (ISIC-4.0) дагуу аймаг, дүүргийн статистикийн мэргэжилтнүүд нөхнө.

Маягт бөглөхөд нягтлан бодогч нарт хялбар болгох үүднээс үзүүлэлт тус бүрт Санхүү, эдийн засгийн сайдын 2000 оны 116 тоот тушаалын хавсралтаар батлагдсан аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн зааврын дансны үндсэн ангиллын 2 оронгийн түвшинд кодыг оруулж өгсөн.

II. Нийт орлого

Борлуулалтын орлого. Борлуулалт гэж тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалтын дүнг хэлнэ. Борлуулалтын үнийн дүнг онцгой татвар ороогүй үнээр нөхнө. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэлээс нь хамаарч үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, лизингийн хүүгийн орлогыг зохих мөрөнд нөхнө.

Борлуулалтын орлогын дүн нь бүлэг III-ийн мөр 301-ийн багана 1 буюу салбар тус бүрийн борлуулалтын орлогын дүнтэй тэнцүү байна. Үзүүлэлт тус бүрт 51-р дансны холбогдох дүнг тавина.

Өөрийн эцсийн хэрэглээнд зориулсан бараа бүтээгдэхүүн. Өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг өөртөө хэрэглэсэн бол түүнийг нийт үйлдвэрлэлийн хэмжээнд оруулж тусгана. Өөрийн хэрэгцээнд хэрэглэсэн бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр үнэлнэ. Эсвэл бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд зарцуулсан зардлын дүнгээр тооцон нийт үйлдвэрлэлтэд оруулж тооцно. *Үзүүлэлт тус бүрт 51-р дансны холбогдох дүнг тавина.*

Улсын төсөөс авсан татаас. Засгийн газраас аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны түвшин, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээ, өртөг, борлуулалт, импортыг үндэслэн буцаан төлөх нөхцөлгүйгээр олгодог урсгал төлбөр юм. Жишээ нь: Эрчим хүч, нийтийн тээвэр, улаан буудай татаас. *Энд 51-р дансны холбогдох дүнг тавина.*

Үндсэн бус үйл ажиллагааны орлого. Энэ хэсэгт үндсэн хөрөнгө худалдсаны орлого, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслэснээс орсон орлого, ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, даатгалын байгууллагаас авсан нөхөн төлбөр, хандив, тусламжийн орлого, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз зэргийг оруулна. *Үзүүлэлт тус бүрт 84-р дансны холбогдох дүнг тавина.*

III. Борлуулалтын орлого, эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар

Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын борлуулалтын орлогыг үйл ажиллагаа эрхлэн явуулж буй чиглэл тус бүрээр нөхнө. Жишээ нь: зочид буудлын орлого, зоогийн газрын орлого, талхны цехийн орлого, жижиглэнгийн худалдааны орлого гэх мэтээр салбар тус бүрийн нэрийг дэлгэрэнгүй бичиж орлогыг нөхнө.

Борлуулалтын орлогын дүн нь бүлэг II-ийн мөр 202-ийн багана 1-ийн борлуулалтын орлогын дүнтэй тэнцүү байна.

IV. Нийт зардал

Тухайн тайлант хугацаанд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад орц байдлаар зарцуулсан бараа, үйлчилгээний материалын зардал болон үйлчилгээний төлбөрийг хамруулж тооцно.

Түүхий эд, материалын зардал. Түүхий эд, материалын зардал нь дахин борлуулахаар биш, харин үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа завсрын орцоор хэрэглэхээр төлөвлөж буй бүтээгдэхүүн орно.

Түүхий эд, материалын зардлын дүн нь бүлэг VII-ийн мөр 701-ийн багана 5 буюу түүхий эд, материал тус бүрийн нийлбэр дүнтэй тэнцүү байна. Энд 14-р дансны холбогдох дүнг тавина.

Дахин борлуулахаар худалдан авсан барааны өртөг. Аж ахуйн нэгж байгууллага буюу бөөний болон жижиглэн худалдаачдын үйлчлүүлэгчдэд борлуулах зорилгоор худалдан авсан бараа байна. *Энд 61-р дансны холбогдох дүнг тавина.*

Үйлчилгээний зардал. Энд бусдаар үйлчлүүлсэн үйлчилгээний дүнгийн нийлбэрийг нөхнө. *Бусдаар үйлчлүүлсэн үйлчилгээний зардлын дүн нь бүлэг VI-ийн мөр 601-ийн багана 1 буюу салбар тус бүрийн үйлчилгээний зардлын нийлбэртэй тэнцүү байна. Энд 31-р дансны холбогдох дүнг тавина.*

Бусад зардал. Үндсэн хөрөнгийн элэгдэл, хандив, тусламжийн зардал, ногдол ашгийн зардал, торгуулийн зардал, гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз зэрэг орно. *Энд 87-р дансны харгалзах дүнг тавина.*

Татвар, хураамж. Бүх төрлийн татвар, хураамж орно. (Үйлчилгээний хураамж орохгүй.)

V. Материаллаг эргэлтийн хөрөнгийн нөөц

Тайлант эсвэл тайлант хугацаанаас өмнө үйлдвэрлэсэн, борлуулахад бэлэн байгаа, эсвэл үйлдвэрлэлийн болон өөр бусад үйл ажиллагаанд хэрэглэхээр төлөвлөж байгаа бүтээгдэхүүнээс бүрдэх хөрөнгө юм.

Түүхий эд, материал (мөр 501) нь дахин борлуулахаар биш харин үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа завсрын орцоор хэрэглэхээр төлөвлөж буй бүтээгдэхүүн орно. *Түүхий эд, материал дүн нь бүлэг VII, мөр 701-ийн багана 1,2 буюу салбар тус бүрийн нийлбэртэй тэнцүү байна. Энд 14-р дансны холбогдох дүнг тавина.*

Хагас боловсруулсан бүтээгдэхүүн (дуусаагүй үйлдвэрлэл) (мөр 502) нь аж ахуйн нэгж, байгууллагаас эдийн засгийн бусад нэгжүүдэд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй байгаа үйлдвэрлэлээс бүрдэнэ. *Энд 14-р дансны холбогдох дүнг тавина.*

Бэлэн бүтээгдэхүүнд (мөр 503) хэдийгээр уг бүтээгдэхүүнийг цаашид үйлдвэрлэлийн өөр боловсруулалтад завсрын хэрэглээгээр ашиглах байсан ч түүний үйлдвэрлэлийн бүх шатны үйл явц бүрэн дууссан бүтээгдэхүүнийг оруулна. *15-р дансны холбогдох дүнг тавина.*

Мал, амьтад (мөр 504) 15-р дансны холбогдох дүнг тавина.

Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүнд (мөр 505) аж ахуйн нэгж, байгууллага буюу бөөний болон жижиглэн худалдаачдын үйлчлүүлэгчдэд борлуулах зорилгоор худалдан авсан бараа байна.

Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүний дүн нь бүлэг VII-ийн мөр 701-ийн багана 3,4 буюу салбар тус бүрийн нийлбэртэй тэнцүү байна. 15-р дансны холбогдох дүнг тавина.

VI. Үйлчилгээний зардал, нэр төрлөөр

Маягтын мөрөнд тусгагдсан үйлчилгээний зардлыг нэр төрлийн дагуу нөхнө.

VII. Түүхий эд, материалын зардал, бүтээгдэхүүний нэр төрлөөр

Зарцуулсан түүхий эд, материалыг бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрээр нөхнө. *Бүлэг IV-ийн мөр 401, багана 1-ын харгалзах дүнтэй тэнцүү.*

VIII. Ажиллагчдын тоо, цалин

Ажиллагчид гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлж буй иргэнийг хэлнэ. Олон улсын нэгдсэн ангиллын дагуу ажиллагчдыг бүтэн, бүрэн бус цагаар ажилладаг ажиллагчид гэж ангилна.

Бүтэн цагаар ажиллагчид гэж байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн ажлын ердийн цаг, эсвэл хууль, тогтоомжийн дагуу хэвшсэн ажлын цагаар ажилладаг ажиллагчид. Мөн тухайн санхүүгийн жилийн турш бүтэн цагаар ажилласан ажиллагчдын сарын дундаж тоогоор ажиллагчдын тоог илэрхийлж болно.

Бүрэн бус цагаар ажиллагчид хөдөлмөрийн гэрээ болон ажил гүйцэтгэх, бусад гэрээний дагуу ажиллаж, долоо хоногийн ажлын цаг, ердийн ажлын өдрийн үргэлжлэлээс бага хугацаагаар ажилладаг ажиллагчдыг хамруулна (Цагийн ажил хийж буй хөдөлмөрийн насны суралцагчийг хамруулахгүй).

IX. Хөрөнгийн нийт хуримтлал

Үндсэн хөрөнгө. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэгээс дээш жил давтан эсвэл үргэлжлэн ашигладаг хөрөнгө бөгөөд үүнд барилга, байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, газрын сайжруулалт, үржлийн мал, олон наст ургамал, оюуны өмчийн хөрөнгө багтана. *20-р дансны холбогдох дүнг тавина.*

Орон сууцны барилга (мөр 902) аль ч улиралд хүн амьдрахад зориулагдсан болон зориулалтын бус барилга, автомашины гарааж зэргийг хамруулна. Тухайлбал, бүх төрлийн байшин, гэр, нийтийн зориулалттай байр, дотуур байр, усан онгоц болон нийтийн зориулалттай орон сууцыг мөн хамруулна.

Бусад барилга, байгууламж (мөр 903) нь орон сууцны бус зориулалттай үйлдвэр, үйлчилгээний барилга, байгууламж, далан, зам, гүүр, шугам, сүлжээ болон газар, хөрс сайжруулалтаас бүрдэнэ.

Машин, тоног төхөөрөмж (мөр 907) нь өрхийн эцсийн хэрэглээнд эзэмшиж байгаагаас бусад тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжөөс бүрдэнэ. Харьцангуй бага үнэтэй болон тогтмол худалдан авдаг гар багаж зэргийг машин, тоног төхөөрөмжид оруулахгүй. Түүнчлэн орон сууцны болон орон сууцны бус барилгын бүтцэд хамрагддаг барилгын салшгүй хэсэг болох машин, тоног төхөөрөмжийг мөн оруулахгүй. Цэрэг дайны зориулалтаар худалдан авсан зэр зэвсгийн системээс бусад машин, тоног төхөөрөмжийг энд оруулна.

Өсөж үрждэг хөрөнгөд (мөр 912) байгууллагын шууд хяналт, удирдлагын дор үр төл болон үр жимсээ байнга давтан өгдөг мал амьтан, мод, ургамлыг хамруулна.

Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийн эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардал (мөр 915) нь газар дээр түгээмэл тохиолддог. Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгөд газар, байгалийн нөөц, баялаг, ус, эрчим хүчний нөөц орно. Эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардалд дараах зардал багтана. Үүнд: Хөрөнгийг худалдан авч байгаа болон худалдаж байгаа хоёр талын мэргэжлийн үйлчилгээний бүх төлбөр, шимтгэ; худалдан авагчаас тусад нь нэхэмжилсэн худалдаа, тээврийн зардал; хөрөнгийн эзэмших эрх шилжүүлэхтэй холбогдон худалдан авагчаас төлөх бүх татвар; хөрөнгийг худалдахтай холбогдуулан төлөх аливаа татвар; худалдан авч байгаа болон худалдаж байгаа хөрөнгийн үнийн дүнд ороогүй угсрах, суурилуулах аливаа зардал; хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, тухайн хөрөнгийн байсан байгаль орчныг сэргээхэд шаардагдах аливаа зардал орно.

Оюуны өмчийн бүтээгдэхүүн (мөр 916) гэж биет шинж чанаргүй, хүний оюуны хүчин чармайлтаар бий болдог, нэг буюу түүнээс дээш жил ашиглагддаг, өөрийн эзэмшигчиддээ давуу болон онцгой эрх, өрсөлдөөний давуу талыг олгосон хөрөнгийг ойлгоно. Үүнд шинжилгээ судалгаа, хөгжлийн ажил, геологи хайгуулын ажил болон үнэлгээ, компьютерийн програм хангамж, мэдээллийн сан, утга зохиол, урлагийн эх бүтээл, лиценз, патент зэрэг орно.

Үнэт зүйлсийн хуримтлал (мөр 924) Үнэт зүйлсийг үнэт металл, чулуу, эртний эдлэл, түүх соёл, гар урлалын бүтээл; бусад гэж ангилна. Үнэт зүйлсийн хуримтлалд үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглагддаггүй, цаг хугацааны явцад хэрэглээний чанар эсвэл бодит үнэ цэнээ алддаггүй, үнэ нь улам нэмэгддэг зүйлс орно.

Үндэсний статистикийн хороо

Утас : 261567